

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019 оны 11 сарын 11 өдөр

**Тендерийн дугаар: МРЦМ/201904528**

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Дундговь аймгийн Иххэт сумын нутагт орших “Зүүн цагаан дэлийн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан хийлгэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь шаардлага хангаж буйгаа нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын ерөнхий танилцуулга,
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/,
- Тусгай зөвшөөрлийн хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/,
- Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар,
- НӨАТ төлөгчийн гэрчилгээ

3. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2019 оны 11 дүгээр сарын 14–ний өдрийн 17:00 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 20–ны өдрийн 09:00 цагаас өмнө **Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.**